



**ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот

**Коронавируст халдвар (Ковид-19)-ын
тархалтыг бууруулах чиглэлээр авч
хэрэгжүүлэх зарим арга хэмжээний
тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Нийслэлийн онцгой комиссын 2022 оны 01 дугаар сарын 17-ны өдрийн 17 тоот чиглэл хүргүүлэх тухай, “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8.7 дохь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын онцгой комиссын 2022 оны 01 дүгээр хурлын тэмдэглэлийн хүрээнд шуурхай ажлын хэсгийн хурлаас өгсөн “Байгууллага аж ахуйн нэгжүүд өмчийн хэлбэр үл харгалзан өөрийн байгууллагад ажиллаж байгаа бага насны хүүхэдтэй 0-5 насны эх, өрх толгойлсон эцэг, эхийг нэг сарын хугацаанд цахимаар ажиллуулж, халдварын эрсдэлээс хамгаалах зохицуулалтын арга хэмжээг авч ажиллах чиглэлийн дагуу байгууллагын 0-5 насны хүүхэдтэй, 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрөөс 2022 оны 02 дугаар сарын 20-ны өдөр хүртэл нэг сарын хугацаанд цахимаар ажиллах эмэгтэй албан хаагчдын нэрсийг нэгдүгээр хавсралтаар, цахимаар ажиллаж, ажлын байрнаас компьютер авах ажилтнуудын нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Цахимаар ажиллах ажилтнуудыг үүрэглүүлж, ажлын гүйцэтгэл болон ирцэд өдөр бүр хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллахыг хэлтсийн дарга нарт (Л.Эрдэнэбат, Л.Ганбат, Р. Амартүвшин, Ш.Энхжаргал, Г.Уранбайгал, В.Мөнхжаргал, Э. Уянга, Б.Гүнжидмаа) үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга (Л.Эрдэнэбат)-д даалгасугай

ДАРГА



Ч.РЭГЗМАА

3150600590